

InvesCore FI

“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№ А/01


Улаанбаатар хот

*Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.9 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 25/02 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА



InvesCore FI

“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№ А/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.5.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 01 тоот шийдвэр болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 25/03 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний бүрэн дуусгавар болсонтой холбогдуулан дараах бүрэлдэхүүнийг 3 (Гурван) жилийн хугацаатай сонгосугай.

Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүд:

- Баянмөнхийн АНХБОЛД
- Далайжамцын БАЯСГАЛАН
- Ралгаагийн ПҮРЭВ
- Япон улсын иргэн ХИРОХИТО НАМИКИ
- Шагдаррагчаагийн ЭРДЭНЭБАТ
- Батхуягийн ЭНХМАРАЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүд:

- Чимэдгочоогийн ӨНӨРЖАРГАЛ
- Чулуундоржийн ХАШЧУЛУУН
- Дангаасүрэнгийн ЭНХБАТ

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг үүрэг болгосугай.
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэх, зохих бүртгэлийг хийлгэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА



InvesCore FI

“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№ А/03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсөв батлах тухай


Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дах заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “**Компани**” гэх)-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.12 дахь заалт болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 25/04 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төсвийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ДАРГА



InvesCore FI



“Инвекор ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмтнийгчдийн
ээлжит хурлын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны
өдрийн А/03 тоот тогтоолын Хавсралт 01

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТӨСӨВ

	Төсөв	Давтамж	Нийт дүн (төг)
1	ТУЗ-ийн гишүүний цалин	12 удаа	138,000,000
2	ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын цалин	12 удаа	12,000,000
3	ТУЗ-ийн хурлын зардал	4 удаа	1,000,000
4	ТУЗ-ийн гишүүдийн сургалтын зардал	1 удаа	5,000,000
5	Бусад	-	5,600,000
6	Нийт дүн	161,600,000	

*2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг
дуустал 12 сарын нэгтгэсэн дүнгээр

InvesCore FI

“ИНВЕСКОР ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР

2025 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

№ А/04

Улаанбаатар хот

*Давуу эрхийн хувьцаа нэмж гаргах, давуу эрхийн хувьцааны нөхцөлд өөрчлөлт оруулах
Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт батлах*

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.8 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.5.3 болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 25/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ** нь:

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хаалттай хүрээнд 100,000,000,000 (Нэг зуун тэрбум) төгрөгийн давуу эрхийн хувьцаа нэмж гаргахаар зарласугай.
2. Энэхүү тогтоолын 1-р зүйлийн дагуу нэмж гаргаж буй давуу эрхийн хувьцааг доорх нөхцөлөөр гарган, Компанийн 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын А/04 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт заасан Компанийн зарласан давуу эрхийн хувьцааны нөхцөлд дараах байдлаар өөрчлөлт оруулан, Компанийн зарласан нийт давуу эрхийн хувьцааны нөхцөлийг ижилтгэсүгэй. Үүнд:

Гаргах хэлбэр	Хаалттай хүрээнд
Зорилго	Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх
Давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнэ	5,000 (таван мянган) төгрөг
Худалдан авах хувьцааны тоо ширхэг	26,000,000 (хорин зургаан сая) ширхэг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	130,000,000,000 (Нэг зуун гучин тэрбум) төгрөг
Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт	Компанийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх
Давуу эрхийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгох дүн	Нэрлэсэн үнээр буюу нэг бүр нь 5,000 (Таван мянган) төгрөг
Давуу эрхийн хувьцааны саналын эрх	Давуу эрхийн нэг хувьцаа Компанийн дүрэмд заасан асуудлаар нэг саналын эрхтэй

InvesCore FI

Давуу эрхийн хувьцааны нөхцөл	Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр эргүүлэн худалдах эсхүл давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаанд хөрвүүлэх
Хувьцаа эзэмшигч давуу эрхийн хувьцааг Компанид эргүүлэн худалдах хүсэлт гаргах хугацаа	Давуу эрхийн хувьцааг гаргасан өдрөөс хойш 5 жилийн дараа
Ногдол ашиг олгох мөнгөн тэмдэгт	Төгрөг
Давуу эрхийн хувьцааг эргүүлэн худалдан авах дүн	Компани давуу эрхийн хувьцааг эргүүлэн худалдаж авах үед Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон зах зээлийн үнэ
Ногдол ашгийн хувь хэмжээ /жилээр/	Монгол банкны бодлогын хүү + Компанийн үйл ажиллагааны ашигт ажиллагаанаас хамааруулан тухай бүр хувь хэмжээг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ. (эзэмшиж буй давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс тооцно)
Ногдол ашгийн хувь хэмжээг тооцох суурь	Тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийн Монгол банкны бодлогын хүүд үндэслэнэ.
Ногдол ашиг олгох нөхцөл	Компани ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор шийдвэрлэнэ. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлийг Хөрөнгө оруулагчдад тайлбарлана. Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд ногдол ашгийг дараагийн санхүүгийн жилүүдэд хуримтлуулахгүй болно.
Татан буулгалтын үнэ	Давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнэ

- Компани энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн хаалттай хүрээнд нэмж гаргаж буй давуу эрхийн хувьцаанаас Компанийн хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжид худалдан авах эрхээ эдлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
- Давуу эрхийн хувьцаа нэмж зарласантай холбогдуулан энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасан нөхцөлийн дагуу 130,000,000,000 (нэг зуун гучин тэрбум) төгрөг хүртэлх дүн эр давуу эрхийн хувьцааг хаалттай хүрээнд гаргаж, давуу эрхийн

InvesCore FI

хувьцаа эзэмшигчид эзэмшүүлсэн тухай бүр Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, түүнтэй холбоотой Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг холбогдох эрх бүхий бүртгэлийн байгууллагууд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д зөвшөөрсүгэй.

5. Давуу эрхийн хувьцаа нэмж гаргаж, давуу эрхийн хувьцааны нөхцөлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасны дагуу Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Хавсралт 1-р баталж, холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэх, зохих бүртгэлийг хийлгэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д даалгасугай.
6. Энэхүү тогтоолд тусгагдаагүй давуу эрхийн хувьцаатай холбоотой бусад асуудалд Компанийн 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын А/04 дугаар тогтоолд заасныг баримталсугай.
7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ДАРГА

